



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/017/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn  Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn  Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn  Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 499

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Засаг даргын харьяаны сумын Засаг даргын Тамгын газарт холбогдох 10,519.7 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн санд холбогдох 91,500.0 мянган төгрөгийн, Биндэр ой ОНӨААТҮГ-т холбогдох 8,827.8 мянган төгрөгийн, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хамаарах 74,647.9 мянган төгрөгийн, нийт 185,495.4 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын Тамгын газрын үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлбэл зохих олон нийтийн цагдаагийн 10,519.7 мянган төгрөгийн цалинг олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Засаг даргын Тамгын газар нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг бүрэн мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүйгээс санхүүгийн тайланд 649,792.5 мянган төгрөгийн 8 алдааг аудитаар залруулсан,

- Биндэр ой анги ОНӨААТҮГ нь талбай тусгаарлалт хийсэн аж ахуйн нэгж байгууллагатай 8,827.8 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Шилэн дансны цахим системийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл цэсэд 91,500.0 мянган төгрөгийн 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээллийг байршуулаагүй,
- Төсвийн төвлөрүүлэн захирагч 2025 оны тодотгосон төсөвт орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийн 51,659.1 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг 22,623.3 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлийг 365.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр тус тус төлөвлөж батлуулсан, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл үйлчилгээний санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй, ОНӨААТҮГ-ын захиралтай гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40.4. "Олон нийтийн байцаагчид энэ хуулийн 34.3-т заасан журмын дагуу урамшуулал олгоно",
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3. "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ыг дагаж мөрдөнө, 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана",
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна", 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"
- ✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2. " ... Сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор" байршуулна, 6.3. "Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.9 "Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл"-ийг мэдээлнэ,
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аймгийн төсвөөс 1,213,560.5 мянган төгрөгийн дэмжлэг авч, 1,000,322.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,568,028.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 247,728.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 50,998.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 44,786.3 мянган төгрөгийг зарцуулж, 6,212.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Аудитаар сумын хэмжээнд нийт 1,499,897.5 мянган төгрөгийн 31 алдаа, зөрчил илэрснээс 716,511.4 мянган төгрөгийн 19 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 3,978.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 779,408.1 мянган төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний хуралдааны 21 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 88.4 хувь, "Үр дүнтэй" гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 558,649.0 мянган төгрөгийн 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 414,581.0 мянган төгрөгөөр 25 арга хэмжээг хэрэгжүүлж, 81,359.0 мянган төгрөгийн 10 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид төсвийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,686,878.67	1,789,758.04
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	701,318.18	711,575.3
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	325,996.93	315,290.46
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	253,702.35	349,859.95
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	405,861.21	413,032.33
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		14,974,313.29	11,936,700.22
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	14,974,313.29	11,936,700.22
8	1.2.2.02 Биет хөрөнгө		14,738,282.84	11,700,695.28
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	236,030.45	236,004.95
<b>10</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>16,661,191.96</b>	<b>13,726,458.26</b>
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		314,394.57	404,438.26
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		314,394.57	404,438.26
13	2.1.1.03 Өглөг		23,926.46	42,197.68
14	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	290,468.11	362,240.58
<b>15</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>16,346,797.39</b>	<b>13,322,020</b>
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		16,346,797.39	13,322,020
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		714,443.51	714,443.51
18	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		217,635.9	217,635.9
19	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		15,140,263.36	12,143,115.99
20	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		274,454.62	246,824.6
<b>21</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>16,661,191.96</b>	<b>13,726,458.26</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,555,663.18	3,913,008.44
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		975,937.42	968,796.33
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		777,956.24	776,073.68
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		777,956.24	776,073.68
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		96,999.86	81,873.33
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		100,981.32	110,849.33
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,764,941.98	2,944,212.1
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,262,982.52

9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,814,783.79	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,068,716.11	4,209,731.12
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		4,068,716.11	4,209,583.79
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,027,050.52	4,206,347.42
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		906,675.61	1,044,497.05
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		111,592.29	206,418.72
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		627,751.38	758,982.39
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		50,886.5	35,704.91
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		440	1,178
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		76,180.71	87,993.28
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		17,800	14,444.8
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,106,113.33	1,120,391.47
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		1,129,610.7	936,736.81
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		41,665.6	3,236.37
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	147.33
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		486,947.06	-296,722.68
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		323,630.63	2,728,054.7
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-323,630.63	-2,728,054.7
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		163,316.43	-3,024,777.38

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,883,555.83	3,858,305.89
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	975,937.42	968,796.33
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	777,956.24	776,073.68
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	96,999.86	81,873.33
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	100,981.32	110,849.33
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,595.27	22,430.46
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	8,100.46	8,697.55
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	68,285.59	79,721.32
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,083,376.48	2,889,509.55

10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,083,376.48	1,218,225.58
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,264,558.67
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	406,725.3
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,824,241.94	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,976.78	3,418,080.64
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,000,976.78	3,418,080.64
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,958,015.03	3,405,864.3
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,227,276.78	1,499,645.25
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,533.5	206,476.88
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	627,751.38	797,987.63
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	626,059.53	538,567.72
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	1,178
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	99,633.98	90,385.72
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	17,800	18,904.8
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,809.82	119,997.12
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	57,150.05	132,721.17
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,961.75	12,216.34
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	882,579.05	440,225.25
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	549,309.4	429,865
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	549,309.4	429,865
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	549,309.4	429,865
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-549,309.4	-429,865
32	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	103.13
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-103.13
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	333,269.66	10,257.12
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	368,048.52	701,318.18
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	701,318.18	711,575.3

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,215,425.75		16,215,425.75

2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,868.16		4,868.16
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,220,293.91		16,220,293.91
4	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	-36,812.95		-36,812.95
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	163,316.43		163,316.43
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,346,797.39		16,346,797.39
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,346,797.39		16,346,797.39
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,630.02		27,630.02
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,374,427.4		16,374,427.4
10	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-27,630.02		-27,630.02
11	1.7 Тайлант үеийн үр дүн	-3,024,777.38		-3,024,777.38
12	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,322,020		13,322,020

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4,569,883.3</b>	<b>4,594,023.5</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>833,018.8</b>	<b>968,796.3</b>
<b>110</b>	<b>3.1.01.1.1.1 Орлогын албан татвар</b>	<b>723,348.8</b>	<b>776,073.7</b>
<b>1100</b>	<b>3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>723,348.8</b>	<b>776,073.7</b>
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	521,848.8	545,046.5
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	120,000.0	137,829.3
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	80,000.0	90,873.5
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,500.0	2,324.4
<b>113</b>	<b>3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар</b>	<b>19,200.0</b>	<b>81,873.3</b>
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	17,000.0	14,442.4
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,200.0	4,712.0
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	-	62,718.9
<b>118</b>	<b>3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>90,470.0</b>	<b>110,849.3</b>
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,130.0	22,430.5
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	5,800.0	5,285.6
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	330.0	1,088.0
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	14,000.0	16,056.8
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	7,000.0	8,697.6
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	7,000.0	8,697.6

1182	3.1.01.1.1.8.3 төлбөр	Байгалийн нөөц ашигласны	63,340.0	79,721.3
118201	3.1.01.1.1.8.3.01 төлбөр	Ойн нөөц ашигласны	33,740.0	50,637.3
118202	3.1.01.1.1.8.3.02 төлбөр	Ан амьтны нөөц ашигласны	29,600.0	29,084.0
<b>12</b>	<b>3.1.01.1.2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>3,736,864.5</b>	<b>3,625,227.1</b>
120	3.1.01.1.2.1	Нийтлэг татварын бус орлого	44,000.0	83,245.8
120003	3.1.01.1.2.1.3	Торгуулийн орлого	25,000.0	30,806.0
120004	3.1.01.1.2.1.4 орлого /үндсэн/	Төсөв байгууллагын өөрийн	-	44,719.8
120010	3.1.01.1.2.1.5 орлого /туслах/	Төсөв байгууллагын өөрийн	18,000.0	7,000.0
120009	3.1.01.1.2.1.9	Бусад орлого	1,000.0	720.0
<b>122</b>	<b>3.1.01.1.2.3</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,286,139.2</b>	<b>3,135,256.0</b>
122003	3.1.01.1.2.3.3	Аймаг нийслэлээс авсан татаас	1,213,560.2	1,213,560.1
122005	3.1.01.1.2.3.5	Төсвөөс санхүүжих	2,072,579.0	1,921,695.9
123	3.1.01.1.2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	406,725.3	406,725.3
123002	3.1.01.1.2.4.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	406,725.3	406,725.3
<b>II</b>	<b>3.1.01.2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,147,831.9</b>	<b>4,965,335.2</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,472,682.9</b>	<b>4,535,470.2</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,463,601.4</b>	<b>2,209,166.4</b>
<b>2101</b>	<b>3.1.01.2.1.1.1</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,154,743.7</b>	<b>1,045,817.6</b>
210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	628,160.6	582,849.3
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	408,000.6	369,341.2
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	60,720.0	47,807.7
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	48,862.5	37,161.8
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	9,000.0	8,657.5
<b>2102</b>	<b>3.1.01.2.1.1.2</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,343.1</b>	<b>128,649.1</b>
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	98,133.3	89,463.1
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	11,547.5	9,889.8
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	5,793.7	5,134.6
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	5,773.7	4,832.3
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	23,094.9	19,329.3
<b>2103</b>	<b>3.1.01.2.1.1.3</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>792,534.9</b>	<b>742,432.0</b>
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	138,164.4	112,554.7
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	631,057.1	614,611.3
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	23,313.4	15,266.0
<b>2104</b>	<b>3.1.01.2.1.1.4</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,120.6</b>	<b>31,006.8</b>
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	5,610.6	3,464.5
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	29,394.4	21,843.3
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,826.9	3,594.0
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,563.8	-
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,724.9	2,105.0

<b>2105</b>	<b>3.1.01.2.1.1.5</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,057.1</b>	<b>1,178.0</b>
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,057.1	1,178.0
<b>2106</b>	<b>3.1.01.2.1.1.6</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>96,363.9</b>	<b>90,385.7</b>
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	5,283.8	350.0
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.1	898.0
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	90,137.0	89,137.7
<b>2107</b>	<b>3.1.01.2.1.1.7</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19,589.0</b>	<b>14,444.8</b>
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	19,589.0	14,444.8
<b>2108</b>	<b>3.1.01.2.1.1.8</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>95,784.8</b>	<b>55,823.9</b>
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,705.4	47,103.0
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,481.7	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,118.3	1,014.0
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	631.5	210.0
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	275.6	-
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,595.4	7,003.0
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	976.9	493.9
<b>2109</b>	<b>3.1.01.2.1.1.9</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>113,064.3</b>	<b>99,428.5</b>
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	106,623.4	94,291.0
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,440.9	5,137.5
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,081.5</b>	<b>2,326,303.8</b>
<b>2131</b>	<b>3.1.01.2.1.4.1</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>2,320,299.8</b>
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	2,320,299.8
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	9,081.5	6,004.0
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,081.5	6,004.0
<b>22</b>	<b>3.1.01.2.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>575,149.0</b>	<b>429,865.0</b>
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	575,149.0	429,865.0
<b>23</b>	<b>3.1.01.2.3</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>100,000.0</b>	<b>-</b>
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	100,000.0	-
<b>8</b>	<b>3.1.01</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>1,422,051.4</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>3.1</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>1,422,051.4</b>
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	1,422,051.4
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	679,197.9
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	706,490.1
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	71	70
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	2

610001	6.1.01	Төсвийн байгууллага	3	2
62	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34	34
620001	6.2.01	Удирдах ажилтан	10	10
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	7	7
620004	6.2.04	Гэрээт ажилтан	4	4
65	6.5	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34	34
650001	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650007	6.5.07	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1	1
650009	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15
650011	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>50,998.6</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>50,998.6</b>
<b>122</b>	<b>1.1.1.1.1.1 Тусламжийн орлого</b>	<b>50,998.6</b>
<b>1221</b>	<b>1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/</b>	<b>50,998.6</b>
<b>12213</b>	<b>1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>50,998.6</b>
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000.0
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,185.6
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,813.0
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>44,786.2</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>44,786.2</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>44,786.2</b>
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,827.5
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	947.5
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480.0
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,250.0
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,250.0
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	30,708.7
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	30,281.6
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	427.1
<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>6,212.3</b>
<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>- 6,212.3</b>
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 6,212.3

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Биндэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Биндэр ой анги ОНӨҮГ, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Биндэр ой анги ОНӨҮГ, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ аудитын түүвэрт хамрагдсан болно.

#### **3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 807,089.3 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илрүүлснээс 696,241.8 мянган төгрөгийн 12 алдаа<sup>1</sup>г санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 110,847.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **ЗДТГ:**

1. Санхүүгийн тайланд 649,792.5 мянган төгрөгийн 8 алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайланд санхүүжилтийн орлогыг 89,764.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Харилцах данснаас төвлөрүүлсэн шилжүүлгийг 17,594.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Цалингийн зардлыг 2,148.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн сумын төвийн зуухны хүчин чадал нэмэгдүүлэх 145,924.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийг орлогоор бүртгээгүй.
- Ашиглалтын хугацаа дуусч данснаас хассан 21,730.8 мянган төгрөгийн 41 төрлийн хөрөнгийг үнэлж орлого авахдаа дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн.
- Их хуралдайн 100,000.0 мянган төгрөгийн газрыг орлогод бүртгэхдээ үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, данснаас хасахдаа хуримтлагдсан элэгдэл дансыг бууруулсан.
- Ажилчдын байрны засварын урьдчилгаанд олгосон 5,000.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, зардалд хаасан
- Данснаас хассан хөрөнгийн элэгдлийн зардлыг 167,483.3 мянган төгрөгөөр илүү тооцсон, тавилга эд хогшлын 147.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бусад хөрөнгийн зардалд бүртгэсэн алдааг тус тус залруулав.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлвэл зохих олон нийтийн цагдаагийн 10,519.7 мянган төгрөгийн цалинг Засаг даргын Тамгын газрын үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3. Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны А/3 дугаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг бүрэн мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүйгээс санхүүгийн тайланд 649,792.5 мянган төгрөгийн 8 алдааг аудитаар залруулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### **Хоршоо хөгжүүлэх сан:**

Хоршоог хөгжүүлэх сангийн тайлант оны 6,549.0 мянган төгрөгийн зээлийн хүү, алдангийг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчлийн залруулсан.

### **Орон нутгийн хөгжлийн сан:**

Шилэн дансны цахим системийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл цэсэд 91,500.0 мянган төгрөгийн 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### **Биндэр ой ОНӨҮГ:**

1. Санхүүгийн тайланд 39,899.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- БОАЖЯ-аас үнэ төлбөргүй ирсэн 216,892.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг урьдчилж орсон орлогод бүртгэснийг тайлант оны элэгдлийн зардлын 25,494.2 мянган төгрөгөөр бууруулаагүй.
- Санхүүгийн тайланд төсвөөс олгосон санхүүжилт, төсөвт төвлөрүүлсэн шилжүүлгийг 10,918.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Талбай тусгаарлалтын төлбөрийн 3,486.8 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн алдааг тус тус залруулав.

2. Талбай тусгаарлалт хийсэн аж ахуйн нэгж байгууллагатай 8,827.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 607,644.9 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснээс 9,754.1 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 3,978.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 593,912.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

### **Соёлын төв:**

1. Санхүүгийн тайланд 9,754.1 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг 8,232.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэмэлт дансны үлдэгдлийг 300.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийн дансанд орлогыг 650.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Цалингаас суутгасан 431.6 мянган төгрөгийн суутгалыг ШШГГ-т шилжүүлээгүй, өглөгөөр тусгаагүй.
- Цалингаас суутгасан ХХОАТ-ыг 140.4 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлагаар тусгаагүй илэрхийлснийг залруулав.

2. Жилийн эцэст 54,513.7 мянган төгрөгийн бараа материал, 142,489.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг бүрэн тоолж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **Ерөнхий боловсролын сургууль:**

1.Тайлант онд 7 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 2,868.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон. Мөн сахилгын шийтгэлтэй албан хаагчид сахилгын шийтгэлтэй хугацаанд 257.6 мянган төгрөг, илүү цагийн нэмэгдэл цагийн 2 албан хаагчид тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн 415.7 мянган төгрөг тус тус олгосон зөрчилд 3,359.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа цахим Tender.gov.mn сайтад мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### **Хүүхдийн цэцэрлэг:**

1. Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 618.6 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант оны нэмэгдсэн үндсэн хөрөнгийг судлахад мэдээллийн технологийн зардал гэсэн эдийн засгийн ангиллын зардлаас зориулалт бусаар зарцуулж зардлын ангилал зөрчиж, 1,525.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд бүх төрлийн худалдан авалтыг хийхдээ "Тендерийн мэдээлэл"-ийг цахим tender.gov.mn мэдээллийн сайтад нийтэд мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Эрүүл мэндийн төв:** Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

### **3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85,163.3 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс 10,515.4 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 74,647.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **1. Санхүүгийн тайлангийн залруулга:**

- Төсвийн орлогын гүйцэтгэлийн тайланд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 3,912.4 мянган төгрөгийн орлогыг ан амьтны нөөц ашигласны нөөц ашигласны төлбөрийн орлогоор зөрүүтэй илэрхийлсэн,
- Замд яваа татварын орлогын 6,603.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

#### **2. Албан шаардлага:**

- Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 13-ны 15 дугаар тогтоолоор сумын 2025 оны төсвийг тодотгон баталсан боловч орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийн 51,659.2 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг 22,623.3 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлийг 365.4 мянган төгрөгөөр тус тус илүү дүнгээр төлөвлөж батлуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- 
- Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл үйлчилгээний санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй, сумын Засаг даргатай гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	89,764.2			1	89,764.2	1	89,764.2				
ЗДТГ	1	17,594.1			1	17,594.1	1	17,594.1				
ЗДТГ	1	2,148.7			1	2,148.7	1	2,148.7				
ЗДТГ	1	145,924.0	1	145,924.0			1	145,924.0				
ЗДТГ	1	21,730.9			1	21,730.9	1	21,730.9				
ЗДТГ	1	200,000.0			1	200,000.0	1	200,000.0				
ЗДТГ	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0				
ЗДТГ	1	167,630.6			1	167,630.6	1	167,630.6				
ХХСан	1	6,549.8	1	6,549.8			1	6,549.8				
Биндэр ой анги	1	25,494.2			1	25,494.2	1	25,494.2				
Биндэр ой анги	1	10,918.4	1	10,918.4			1	10,918.4				
Биндэр ой анги	1	3,486.8	1	3,486.8			1	3,486.8				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>12</b>	<b>696,241.7</b>	<b>4</b>	<b>166,879.0</b>	<b>8</b>	<b>529,362.7</b>	<b>12</b>	<b>696,241.7</b>				
Соёлын төв	1	8,232.1			1	8,232.1	1	8,232.1				
Соёлын төв	1	300.0			1	300.0	1	300.0				
Соёлын төв	1	650.0			1	650.0	1	650.0				
Соёлын төв	1	431.6	1	431.6			1	431.6				
Соёлын төв	1	140.4	1	140.4			1	140.4				
<b>УТБ-ын дүн</b>	<b>1</b>	<b>8,232.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>8,232.1</b>	<b>1</b>	<b>8,232.1</b>				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>1</b>	<b>6,603.0</b>	<b>1</b>	<b>6,603.0</b>			<b>1</b>	<b>6,603.0</b>				
<b>Дүн</b>	<b>14</b>	<b>711,076.8</b>	<b>5</b>	<b>173,482.0</b>	<b>9</b>	<b>537,594.8</b>	<b>14</b>	<b>711,076.8</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	10,519.7			2	10,519.7						
Биндэр ой анги	1	8,827.8			1	8,827.8						
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>7</b>	<b>19347.5</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>19,347.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
ЕБС	2	256,115.5	1	3,359.4	1	252,756.1						
Цэцэрлэг	2	2,143.7	1	618.7	1	1,525.0						
Соёлын төв	1	227.8	1	227.8								
<b>УТБ-ын дүн</b>	<b>5</b>	<b>258,487.0</b>	<b>3</b>	<b>4,205.9</b>	<b>2</b>	<b>254,281.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

ТТЗ	2	74,647.9			2	74,647.9						
ТТЗ-ийн дүн	2	74,647.9	0	0	2	74,647.9	0	0	0	0	0	0
Дүн	14	352,482.4	3	4,205.9	7	348,276.5	0	0	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	91,500.0			1	91,500.0		
Цэцэрлэг	1	142,628.9			1	142,628.9		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>234,128.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>234,128.9</b>	<b>0</b>	<b>0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0		0	-	0	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>234,128.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>234,128.9</b>	<b>0</b>	<b>0</b>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 262 - А2370447 Чингис хот  
ХЭА-2026/017/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын 2025 оны төсвийг тодотгон баталсан боловч орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийн 51,659,157.00 (тавин нэгэн сая зургаан зуун тавин есөн мянга нэг зуун тавин долоон) төгрөгийг бүрэн төлөвлөөгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг 22,623,299.00 (хорин хоёр мянга зургаан зуун хорин гурван мянга хоёр зуун ерэн есөн) төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлийг 365,411.00 (гурван зуун жаран таван мянга дөрвөн зуун арван нэгэн) төгрөгөөр тус тус илүү дүнгээр төлөвлөж батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх"; 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх"; 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ"; 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаар, багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биндэр сумын Засаг дарга Ц.Дэмбэрэлсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 263-А/2370447

Чингис хот

ХЭА - 2026/017/НА-СТА-ТТЗ

Г

Зөрчлийг арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл үйлчилгээний санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй, ОНӨААТҮГ-ын захиралтай гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна", 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталдаггүй, хэрэгжилтийг дүгнэдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ц.Дэмбэрэлсайханд даалгаа.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112